

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ нь:**

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Мандал голомт” ХХК /С.Дарамдад/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 225 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.САМДАН

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,070.0
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ 35,117.4
		тогтмол	Төг/м ³ 1,152.3
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	1,800.0
4	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ 30,536.9
		тогтмол	Төг/м ³ 1,002.0
5	Төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/Гкал	3,400.0
		Төг/м ³	2,000.0
		Төг/хүн	3,000.0
6	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0” –ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	800.0
7	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар 3,000.0
		41-81 м ² талбайтай айл өрх	Төг/сар 5,000.0
		81 м ² -с дээш талбайтай айл өрх	Төг/сар 10,000.0